



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 11540.

Арвайхээр

Г Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа
иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтын
ажилд оролцуулах тухай

Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3, Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.5, 3.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн сумдын онцгой байдлын штабт 2021-2023 онд цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг Хархорин суманд байрлах “ӨВ АГРО” ХХК-ийн гурил тэжээлийн үйлдвэрийн малын ногоон тэжээл хураах, нөөцийн агуулахад буулгах орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс 14 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгүүлсүгэй.

2.Орон нутгийн бүтээн байгуулалтад оролцож байгаа цэргийн дүйцүүлэх албан хаагчдыг чанартай хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр тасралтгүй хангаж, хөдөлмөр аюулгүйн ажиллагааны зааварчилгааг өдөр бүр танилцуулж, аюулгүй байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллуулахыг “ӨВ АГРО” гурил тэжээлийн үйлдвэр ХХК (Р.Намгилрагчаа)-д хариуцуулсугай.

3.Орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцох цэргийн дүйцүүлэх алба хаагчдын хувийн бэлтгэл, дулаан хувцсыг бэлтгүүлж, тогтоосон хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт бэлэн байлгахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4.Цэргийн дүйцүүлэх алба хаагчдын бүтээн байгуулалтын ажилд оролцож буй байдалд байнгын хяналт тавин удирдлага зохион байгуулалтаар хангаж, алба хаах тооцооны дэвтэрт тэмдэглэл хийж баталгаажуулахыг Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



.: 011101144

D:My Doc. Zahiramj. Zasag darga